



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/360

Алтай хот

Улсын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны "Зөвлөмж батлах тухай" 229 дүгээр тушаал, 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн АОСКААТҮГ-02/2021-1 дугаартай Есөнбулаг сумын "Солонго хороолол"-д баригдсан 50 айлын орон сууцны барилгын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: М.Мандахүү (Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Н.Пүрэвдулам (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Д.Отгонжаргал (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Батбилэг (Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Н.Золжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)

М.Туул (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн)

2.

- Д.Баярчулуун ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн техник бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга бөгөөд дэд станц, туршилт нормчлолын инженер)
- М.Цэлмэгтуяа ("Солонго дулааны станц" ААТҮГ-ын ерөнхий инженер)
- Д.Цэвэлмаа ("Мэдээлэл харилцаа холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
- Д.Байгальмаа ("Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын ашиглалтын инженер)
- Ч.Нарандэлгэр ("Барилга байгууламж" ХХК-ийн захирал)
- Ш.Болдбаатар ("Мөрөн Алтай" ХХК-ийн захирал)
- Ш.Ариунаа (Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Говь- Алтай аймгийн зөвлөлийн тэргүүн)
- Б.Цэрэндаваа ("Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ын ерөнхий инженер (захиалагч))

Нарийн бичгийн дарга: Д.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий

2. Барилга, байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээн авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг хийж, Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу цаашдын ашиглалт, арчилгаа хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-т хариуцуулсугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

